# Коронавируст халдвар (КОВИД-19)-ын вакцины талаар иргэдийн авч буй мэдээллийн эх сурвалжийг судалсан нь

*Б.Баярмаа[1], А.Ган-Эрдэнэ[2], Д.Даваалхам[2], Х.Нансалмаа[2], Б.Билэгт[2], Ч.Өнөрцэцэг[2], Д.Надмидцэрэн[2], Д.Оюунбилэг[2], Д.Авирмэд[2], Ц.Нямсүрэн[3]*

*[1]Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв*
*[2]АШУҮИС, Нийгмийн эрүүл мэндийн сургууль*
*[3]Монгол Улсын Их сургууль, Шинжлэх ухааны сургууль*
*Цахим шуудан: nyamsuren.ts@num.edu.mnУтас:91199633*

**Түлхүүр үг:**

Коронавируст халдвар (КОВИД-19)
Вакцин
Мэдээлэл
Эх сурвалж

**Товч утга:** Коронавируст халдвар (КОВИД-19)-ын вакцины талаар иргэдийн мэдээлэл авч буй эх сурвалжийг тодорхойлох зорилгоор 2021 оны 2-3 дугаар сард Монгол Улсын хэмжээнд хот, хөдөөгийн 18-аас дээш насны нийт 1040 хүн амыг агшингийн судалгааны загвар ашиглан онлайнд суурилсан маягтаар, санамсаргүй түүврийн аргаар судалгаанд хамруулав. Судалгаанд оролцогчид олон нийтийн телевиз, цахим орчин тэр дундаа фэйсбүүк (facebook), цахим мэдээллийн сайтуудаас коронавируст халдвар (КОВИД-19) вакцины талаарх мэдээлэл авсан байна. Богино видео хэлбэрээр бэлтгэсэн мэдээлэл иргэдэд хамгийн хүртээмжтэй байна. Судалгаанд оролцогчдын (53.7%) Коронавируст халдвар (КОВИД-19) вакцинд хамрагдана гэж байгаа бол (39.7%) нь эргэлзэж, (6.6%) нь хамрагдахгүй гэжээ. Мэдээллийн албан ёсны эх сурвалж, мэргэжлийн судалгааны сэтгүүлүүдээс мэдээлэл авдаг иргэдийн хувьд вакцинд хамрагдах хандлага илүү байна. Манай Улсад 2020 оны 6, 7 дугаар сард хийгдсэн судалгаагаар иргэдийн (42.4%) нь цаашид шинэ вакцины талаарх мэдээлэл хэрэгцээтэй гэж үзэж байсан бол бидний судалгаагаар мэдээллийн хэрэгцээ илүү өндөр үзүүлэлттэй буюу (72.3%) байна. Давхардсан тоогоор иргэдийн (65.4%) нь вакцины чанар, (62%) нь аюулгүй байдлын тухай тодорхой мэдээлэл авахыг хүсч байгаа нь вакцинжуулалт эхэлсэнтэй холбоотой байх магадлалтай.

**Үндэслэл:** Манай Улсын хувьд 2021 оны 4 сарын 02-ны байдлаар ДЭМБ-ын зөвшөөрөлтэй 4 төрлийн вакциныг хүлээн авч 3 төрөл (Oxford-AstraZeneca-COVISHIELD, Sinopharm-Vero cell, Pfizer BioNTech)-ийн вакцинаар дархлаажуулалтын 43 цэг 323.690 иргэнийг эхний тунд хамруулжээ.[1]

Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас шинээр нэвтрүүлэх вакциныг хүн амын ихэнхи хэсэг хүлээн зөвшөөрөх нь вакцинжуулалтын үр дүнд чухал нөлөөтэй бөгөөд иргэд уламжлалт мэдээллийн хэрэгслээс гадна янз бүрийн мэдээллийн эх сурвалжаас мэдээлэл авах, ялангуяа нийгмийн сүлжээгээр дамжуулан хяналтгүй, шүүлтүүргүй мэдээллийг хүлээн авах, түгээх, хуваалцах боломжтой болсон нь вакцинд эргэлзэх байдлыг нэмэгдүүлж, вакцинд итгэх олон нийтийн итгэлийг бууруулж байна гэжээ.[2]

2020 оны 9-р сард Их Британи, АНУ-д хийгдсэн судалгаагаар цахим орчин дахь буруу ташаа мэдээлэл нь "заавал" вакцин хийлгэх хүмүүсийн дунд вакцин хийлгэх хандлагыг 6.4 хувиар бууруулж байгааг тодорхойлсон. Иймд мэдээлэл, сурталчилгааны компанит ажлыг түлхүү хийхийг зөвлөмж болгосон байна.[3]

Монгол Улсын хүн амын (51%) нь коронавируст халдвар (КОВИД-19)-ийн халдварын 3 ба түүнээс дээш шинж тэмдгийг мэдэж байсан бол (3%) нь ямар ч мэдээлэлгүй ба (52%) нь эрүүл мэндийн ажилтнуудаас мэдээлэл авдаг бөгөөд тэдгээрийн (62%) нь эмч, мэргэжилтнүүдийн зөвлөгөө мэдээлэлд итгэдэг байна. Радиогоос коронавируст халдвар (КОВИД-19)-ийн талаар мэдээлэл авдаг иргэд (13%)-ийг эзэлж байсан бол тэдгээр иргэдийн (39%) нь авсан мэдээлэлдээ итгэдэг гэжээ.[4] АШУҮИС-ийн НЭМС-ын хийсэн судалгаагаар иргэдийн (59.8%) нь коронавируст

халдвар (КОВИД-19) вирусын эмчилгээ болон вакцины талаар илүү мэдэхийг хүсч байсан байна. Мөн вакцин хийлгэхийг санал болговол иргэдийн (46.1%) хамрагдана гэжээ.[5] Коронавируст халдварын талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадал ойлголтыг тогтоох судалгаанд хамрагдсан 1740 түүвэр хүн амын дийлэнх нь буюу (83.4%) нь цар тахалтай холбоотой мэдээллийг олон нийтийн телевизээс авч байсан ба цаашид шинэ вакцины талаарх мэдээллийг (42.4%) нь шаардлагатай гэж үзжээ.[6] Манай улс 2021 оны 07 сарын 1-нээс өмнө нийт иргэдийнхээ (60%)-ийг вакцинжуулахаар төлөвлөн ажиллаж байна.[7] Вакцинжуулалтыг үр дүнтэй зохион байгуулахын тулд вакцины мэдээлэл иргэдэд хэрхэн хүрч байгаа эсэхийг судлах хэрэгцээ үүсч байна.

**Зорилго:** Энэхүү судалгааны зорилго нь коронавируст халдвар (КОВИД-19) вакцины талаар иргэдийн мэдээлэл авч буй эх сурвалжийг тодорхойлох

**Зорилт:**

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын вакцины талаар иргэдийн мэдээлэл авч буй эх сурвалжийг тодорхойлох
2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын вакцины талаар иргэдийн мэдээлэл авах хэрэгцээг судлах
3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын вакцины талаарх хандлагыг тодорхойлох

**Материал ба арга зүй:** Судалгаанд хүн амд суурилсан агшингийн судалгааны загварыг ашиглав.
*Хамрах хүрээ, судалгаанд хамрагдах иргэдийн түүвэрлэлт:* Монгол Улсын хэмжээнд 18-аас дээш насны хүн амын тоог (n=2009271) суурь үзүүлэлт болгон тооцож, хот, хөдөөгийн 1040 хүн амыг санамсаргүй түүврийн аргаар сонгов.
*Мэдээлэл цуглуулсан арга, судалгааны хэрэглэгдэхүүн:* Иргэдийн нас, хүйс, боловсрол, ажил эрхлэлт, ам бүл, өрхийн орлого, Коронавируст халдвар (КОВИД-19) вакцины талаарх мэдлэг, мэдээлэл авч буй эх сурвалжийг хоёр бүлэг 51 асуултаар тодорхойллоо. Асуумжийг онлайнд суурилсан маягт хэлбээр боловсруулж, судалгааны мэдээллийг цуглуулав.
*Ёс зүй:* Судалгааны ажлын ёс зүйн зөвшөөрлийг 2021 оны 3 сарын 19-ний өдрийн ЭМЯ ны ёс зүйн хяналтын хорооны хурлаар хэлэлцүүлж авсан болно.

**Үр дүн:** Судалгаанд нийт 1003 иргэн оролцсоноос хөдөө орон нутгийн (31.4%), Улаанбаатар хотын иргэд (68.6%)-ийг эзэлж байна. Хүйсийн хувьд эмэгтэй (71.2%) оролцогч давамгайлжээ. Судалгаанд залуучууд идэвхитэй оролцсон (62.1%) бол хамгийн бага хувийг (6.2%) ахмадууд эзэлж байна. Боловсролын хувьд дээд боловсролтой иргэд (47.6%)-ийг эзэлж байгаа бол бүрэн дунд болон тусгай дунд боловсролтой иргэд (33.8%)-ийг эзэлж байна. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын вакцины талаарх мэдээллийг (65.1%) нь Засгийн Газар, Улсын Онцгой комиссын албан ёсны мэдээллээс авч байна. Иргэдийн (46.4%) нь коронавируст халдвар (КОВИД-19) вакцины талаар өдөр бүр мэдээлэл авч байгаа бол, (28.1%) нь 2-3 хоногийн өмнө мэдээлэл авсан байна.

Иргэдийн боловсролын түвшин нэмэгдэх тусам албан ёсны эх сурвалжаас мэдээлэл авах хандлагатай (59.5%) байгаа нь ажиглагдлаа. Харин ажлын хамт олон (10.4%), гэр бүлийн гишүүд (12%), найз нөхдөөс (8.3%) мэдээлэл авч буй байдал харьцангуй бага хувийг эзэлжээ. Эмэгтэйчүүдийн хувьд коронавируст халдвар (КОВИД-19) вакцины талаарх мэдээллийг Эрүүл мэндийн яам (ЭМЯ)-ны албан ёсны эх сурвалж (74%) болон ажлын хамт олноос (78.8%) түлхүү авч байхад эрэгтэйчүүдийн хувьд цахим сүлжээнээс (51.1%) илүү мэдээлэл авч байна.

Цаашид мэдээллийг (62.1%) нь телевизээр, (40.1%) нь цахим сүлжээгээр тэр дундаас фэйсбүүк (facebook)-ээр авахыг илүүд үзэж байна. Түүнчлэн (45.2%) нь мэдээлэл авах хэрэгцээ маш их, (27.1%) нь их байна гэж хариулжээ. 26-45 насныханд коронавируст халдвар (КОВИД-19) вакцины талаарх мэдээлэл авах хэрэгцээ илүү өндөр байгаа нь статистик ач холбогдол бүхий ялгаатай байлаа (P<0.001).

Вакцины гаж нөлөө, үр дагавар, дархлаа тогтоох үйл явц, эсрэг заалт болон хэн хаана, хэзээ ямар вакцин хийлгэх тухай мэдээллийг сонирхож байгаагаа хэлсэн байна. Коронавируст халдвар (КОВИД-19) вакцин хийлгэнэ хэмээн төлөвлөж байгаа иргэдийн хувьд вакцины ач холбогдол (68.5%), вакцинжуулалтын зохион байгуулалт (60.8%), дараллыг (65%) илүү сонирхож байгаа нь статистик ач холбогдол бүхий ялгаатай байна (P<0.004). Иргэдийн Коронавируст халдвар (КОВИД-19) вакцин хийлгэсний дараа авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх ойлголтуудыг тодруулахад ЭМЯ-ны албан эх сурвалж, мэргэжлийн сэтгүүлээс мэдээлэл авдаг иргэдийн мэдлэг өндөр байна.

Судалгаанд оролцогч 2 хүн тутмын нэг нь вакцинд хамрагдана гэж байгаа бол (39.7%) нь эргэлзэж, (6.6%) нь хамрагдахгүй гэжээ. Вакцин хийлгэх талаар эргэлзэж буй иргэдийн хувьд вакцины талаарх мэдээллийг гэр бүлийн гишүүд (45.8%), нийгмийн сүлжээ (facebook, twitter г.м.)-нээс (43.7%) авч байгаа нь бусад эх сурвалжтай харьцуулахад өндөр байна. Ямар нэгэн ажил эрхэлдэггүй, гэртээ суудаг иргэдийн хувьд вакцинд эргэлзэх байдал бусадтай харьцуулахад өндөр (54.8%) гарч байна (P<0.002)

**Хэлцэмж:** Өмнө нь хийгдсэн судалгаагаар Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын талаарх мэдээллийг иргэдийн (82%) нь цахим эх сурвалжаас авч байсан бол тэдний (33%) нь тус эх сурвалжийн мэдээллийг найдвартай хэмээн итгэж байжээ.[6] Бидний судалгаагаар коронавируст халдвар (КОВИД-19) вакцины талаарх мэдээллийг (48.6%) нь телевизээр, (39.7%) нь нийгмийн сүлжээ (Facebook, Twitter)-гээр дамжуулан авдаг ба (53.7%) нь мэдээлэлд итгэдэг, найдвартай гэж боддог бол (42.3%) нь эргэлздэг, (4%) нь огт санал нийлдэггүй буюу хүлээн зөвшөөрдөггүй байна. Итали Улсад 2020 оны 6-р сард явуулсан онлайн судалгаагаар Коронавируст халдвар (КОВИД-19)-ын вакцины талаарх төсөөлөл, итгэл үнэмшил нь ихэнхдээ эерэг байсан бөгөөд энэ нь вакцины талаарх мэдлэгтэй шууд хамааралтай буюу

наснаас илүү боловсролын түвшинтэй холбоотой[8] гэсэн нь бидний судалгааны үр дүнтэй ойролцоо буюу мэдлэг нь боловсролын байдалтай шууд хамааралтай байна.

Манай Улсад 2020 оны 6, 7 дугаар сард хийгдсэн судалгаагаар иргэдийн (42.4%) нь цаашид шинэ вакцины талаарх мэдээлэл хэрэгцээтэй6 гэж үзэж байсан бол манай судалгаагаар мэдээллийн хэрэгцээ илүү өндөр үзүүлэлттэй байна.

**Дүгнэлт:**

1. Судалгаанд оролцогчид олон нийтийн телевиз, цахим орчин тэр дундаа фэйсбүүк (facebook), цахим мэдээллийн сайтуудаас коронавируст халдвар (КОВИД-19) вакцины талаарх мэдээлэл авч байна. Богино видео хэлбэрээр бэлтгэсэн мэдээлэл иргэдэд хамгийн хүртээмжтэй байна.
2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын вакцины талаар мэдээлэл авах хэрэгцээ өндөр (72.3%) байна. Давхардсан тоогоор иргэдийн (65.4%) нь вакцины чанар, (62%) нь аюулгүй байдлын тухай тодорхой мэдээлэл авахыг хүсч байгаа нь вакцинжуулалт эхэлсэнтэй холбоотой байх магадлалтай.
3. Судалгаанд оролцогчдын (53.7%) нь Коронавируст халдвар (КОВИД-19) вакцинд хамрагдана гэж байгаа бол (39.7%) нь эргэлзэж, (6.6%) нь хамрагдахгүй гэжээ. Мэдээллийн албан ёсны эх сурвалж, мэргэжлийн судалгааны сэтгүүлүүдээс мэдээлэл авдаг иргэдийн хувьд вакцинд хамрагдах хандлага илүү байна.

**Ном зүй:**


1. *Эрүүл мэндийн яам. Коронавируст халдвар (КОВИД-19)-ийн өвчлөл, нас баралтын мэдээлэл.Covid19.monhs.mn. Дөрөвдүгээр сарын 2, 2021.*
2. *Palm, Risa, Toby Bolsen, and Justin T. Kingsland. "The effect of frames on COVID-19 vaccine hesitancy." MedRxiv (2021). Cit.03/17/2021*
3. *Loomba, Sahil, et al. "Measuring the Impact of Exposure to COVID-19 Vaccine Misinformation on Vaccine Intent in the UK and US." medRxiv (2020). Cit.03/12/2021*
4. *John Hopkins university. "Knowledge of Covid-19 symptoms and treatment". 2021. https://ccp.jhu.edu/kap-covid/kap-covid-country-profiles-with-demographic-disaggregation/. Cit.02/12/2021*
5. *Ц.Нямсүрэн, & ба бусад. "Коронавируст халдвар (КОВИД-19) цар тахлын үеийн олон нийтийн төсөөлөл, сэтгэлзүй, зан үйл".2020.*
6. *ЭМЯ, НЭМҮТ & ба бусад. "Коронавируст халдварын талаарх хүн амын мэдлэг, хандлага, дадал ойлголтыг тогтоох судалгаа, Монгол Улс". 2020.*
7. *Э.Тэмүүлэн. Вакцины хоёр тунгаа хийлгэснээс хойш 7-14 хоногийн дараа дархлаа бүрэн тогтоно. https://mn.emg.ub.gov.mn/en/trend-post/2928. Гуравдугаар сарын 10, 2021.*
8. *Biasio, Luigi Roberto, et al. "Assessing COVID-19 vaccine literacy: a preliminary online survey." Human vaccines & immunotherapeutics 17.5 (2021): 1304-1312. Cit.03/25/2021*


# Of citizens' information sources on coronavirus (COVID-19) vaccine


*Bayarmaa B[1], Gan-Erdene A[2], Davaalkham D[2], Nansalmaa Kh[2], Bilegt B[2], Unurtsetseg Ch[2], Nadmintseren D[2], Oyunbileg D[2], Avirmed D[2], Nyamsuren Ts[3]*

*[1]National Public Health Center*
*[2]MNUMS, School of Public Health*
*[3]National University of Mongolia, School of Arts and Sciences*
*Email: nyamsuren.ts@num.edu.mn, Tel: 91199633*



A nationwide cross-sectional study was conducted to determine the public's information source on coronavirus (COVID-19) vaccines. A total of 1040 participants aged over 18 from cities and provinces were selected using simple random sampling. Data collection was based on an electronic survey.

TV and social networks especially Facebook were the main information source of coronavirus (COVID-19) vaccine among participants in this study. Information prepared in the form of short videos was the most accessible to the public. Of the total participants, 53.7% answered they would be vaccinated against the coronavirus (COVID-19) vaccine, 39.7% were sceptical, and 6.6% were not willing to be vaccinated. Participants who receive information from official sources and professional research journals were more likely to be vaccinated.

According to a survey conducted in Mongolia in June and July 2020, 42.4% of citizens said that they need information about new vaccines in the future, while according to our survey, the need for information is even higher, or 72.3%. In duplicate, 65.4% of the population would like to know more about the quality of the vaccine and 62% about the safety, which may be related to COVID-19 vaccine rollout.



**Keywords:** Coronavirus infection, COVID-19, vaccine, information, source